

НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР

2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024 оны 07 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 27 зорилт, 149 арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөн, Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хянан батлуулав. Үүнд:

Д/д	ДЭД САЛБАР	ЗОРИЛТ	АРГА ХЭМЖЭЭ
1	2	3	4
1	Орон зайн оновчтой төлөвлөлт	15	65
2	Хуулиар хүлээх чиг үүрэг	11	79
3	Дүрмээр хүлээх чиг үүрэг	1	5
НИЙТ		27	149

ЗОРИЛГО 1. ОРОН ЗАЙН ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 28 дугаар хуралдаанаар “Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-ний төслийг хэлэлцүүлж, хуралдаанаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан Олон Улсын байгууллагаас зөвлөгөө, зөвлөмж авч холбогдох мэргэжлийн болон төрийн бус байгууллага, Шинжлэх ухааны академи, их дээд сургуулийн багш, эрдэмтэн судлаач, иргэд олон нийтийн оролцоог ханганд боловсруулж танилцуулахыг даалгасан. “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний Зөвлөх үйлчилгээний ажлын удирдамж, ажлын даалгаврыг боловсруулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар батлуулсан. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас Зөвлөх үйлчилгээний тендер зохион байгуулж, “Дэхан консалтентс” ХХК шалгарсан. Шалгарсан “Дэхан консалтентс” ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр НХААГ/20240103147 тоот гэрээг байгуулсан. Гэрээний дагуу Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Зайсан толгой орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулна.


Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/372 дугаар захирамжийг үндэслэн Зайсан толгой орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгавар №2023/10 дугаартай батлагдсан. Зайсан толгой орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг Байгаль орчин аялал жуулчлалын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтран баталсан 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 2024/01, 03 тоот дугаартай зургийн даалгаврыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт 2024 оны 01-02/576 тоот, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 01-02/638 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Уг шалгаруулалтад Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ, Гоби трэйвэл ХХК-аас оролцсон боловч материалын шаардлага хангахгүй үндэслэлээр буцаагдаж, холбогдох тайлбар, гомдлыг ирүүлээгүй тул сонгон шалгаруулалтыг дахин

зохион байгуулахаар болсон. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас төсөл сонгон шалгаруулалтыг 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн зарыг байршуулсан бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр тендерийг нээсэн. Улмаар төсөл хэрэгжүүлэгчээр “Гоби трэйвэл” ХХК шалгарсан. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 03/1151 тоот албан бичгээр “Гоби трэйвэл” ХХК-д гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлсэн. Мэдэгдлийн дагуу “Гоби трэйвэл” ХХК-тай Захиалагчийн гэрээ байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



Улаанбаатар хотын төлөвлөлтийн 27 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай А/893 дугаар захирамжаар “Яармаг” хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулахыг Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, хөгжлийн газарт тус тус даалгасан. Тус захирамжийн хүрээнд “Яармаг” хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын гэрээ 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 2023/A/893/01 дугаартай батлагдаж, дундын тайланг 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 39 дүгээр хурлаар хэлэлцүүлж, зөвлөлийн гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тусган ажлын гүйцэтгэлийг сайжруулан дахин хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/580 дугаартай албан бичгээр гэрээний хугацаа сунгах хүсэлт ирүүлсэн тул 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 2023/A/893/02 дугаар бүхий хугацаа сунгах нэмэлт гэрээгээр ажлын хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгасан. Тус ажлын дундын тайланг 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 9 дүгээр хурлаар дахин хэлэлцүүлэн дэмжигдэн, хурлын гишүүдийн санал дүгнэлтийн дагуу сайжруулан гүйцэтгэлийг хүлээн авахаар ажиллаж байна.



Хот байгуулалтын мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийн бүрэн бүтэн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн сангийн найдвартай ажиллагааг хангах, техник, тоног төхөөрөмжийг шинэчилнэ.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/279 дүгээр захирамжаар худалдан авах ажиллагааны эрхийг тус газарт, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Цахим хөгжлийн мэдээлэл технологийн газарт шилжүүлсэн.

Газрын даргын 2024 оны А/19 дүгээр тушаалаар уг ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулагдсан. 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр tender.gov.mn цахим системд тендерийг зарлаж, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр тендерийг нээсэн. Үнэлгээний хорооны тендер үнэлэх, шалгаруулах хурал 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж, шаардлага хангасан "Ногун" ХХК шалгарсан. Гэрээ байгуулах эрх олгох, зөвлөмж хүргүүлэх тухай 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01-06/97 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. Гэрээ байгуулснаас 30 хоногийн дотор тоног төхөөрөмжийг нийлүүлнэ.

Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг хийнэ.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/234 дүгээр захирамжаар уг ажилд Захиалагчийн хяналт тавих эрхийг тус газарт шилжүүлсэн. Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 5.7.3-т заасныг үндэслэн ГЗБГЗЗЕГ-аас ажлын даалгаварт тусгах саналыг хүлээн авч, даалгаврыг нэгтгэн боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01-05/837 дугаартай албан бичгээр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргаар батлуулсан Ажлын даалгавар, хийгдэх ажлын хил зааг, түүний эргэлтийн цэгийн солбицол бүхий материалыг хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр tender.gov.mn цахим системд тендерийг зарлаж, 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр тендерийг нээсэн. Үнэлгээний хорооны тендер үнэлэх, шалгаруулах хурал 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр хуралдаж, шаардлага хангасан "Геосан" ХХК-ийг шалгарсан. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас гэрээ байгуулах эрх олгосон зөвлөмж ирүүлэхийг хүлээж байна.

Сэлбэ дэд төв орчмын гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн зураг төсөөв, газар чөлөөлөлт, барилгаа угсралтын ажлыг эхлүүлнэ. Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо/

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1234 дүгээр захирамжийн дагуу “Сэлбэ дэд төвөөс Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо руу инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ татах ажлын зураг төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний гэрээг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай байгуулан Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 14, 16, 18 дугаар хороо/

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1234 дүгээр захирамжийн дагуу “Сэлбэ дэд төвөөс Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо руу инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ татах ажлын зураг төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний гэрээг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай байгуулсан. Тус ажлын хүрээнд хийгдсэн барилгажилтын төслийн дагуу усны барилга байгууламжийн шугамын ажлын зураг төсөл, дулаан хангамж, цахилгаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын төлөвлөлтийн шийдэл, ажлын зураг төслийг зөвшилцсэн. Барилгажилтын төслийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн техникийн хурлаар хэлэлцэж, СДС012/2023, СДС13/2023, СДС14/2023, СДС11/2023 Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГазраас дулаан хангамжийн техникийн нөхцөл, “МХС” ХХК-аас олгосон D-U2023/279 холбооны худаг сувагчлалын техникийн нөхцөлийн хүрээнд “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ боловсруулсан гадна дулааны шугам сүлжээний ажлын зургийг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зөвшилцэж, Хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийн хүрээнд 2024 онд 2 байршилд 296 айлын, үйлчилгээтэй орон сууц ашиглалтад орсон. Үүнд:

- Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны “Хару констракшн” ХХК-ийн 13 дугаар байр буюу 94 айлын үйлчилгээтэй орон сууц,
- Баянгол дүүргийн 2 дугаар хорооны “Грэйт роуд” ХХК-ийн 202 айлын үйлчилгээтэй орон сууц.



“Хару констракшн” ХХК-ийн 94 айлын үйлчилгээтэй орон сууц,



“Грэйт роуд” ХХК-ийн 202 айлын үйлчилгээтэй орон сууц.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтад нийт 13 байршилд шаардлагатай 43,413.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын өргтийг шийдвэрлүүлэхээр 2023 оны 01/08/3133 дугаартай албан бичгээр төсвийн тодотгол, 2024 оны нийслэлийн төсөвт 01/01/1546 дугаартай албан бичгээр саналыг хүргүүлсэн. Тус шугамын бүтээн байгуулалтын ажил хийгдсэнээр 2172 айлын орон сууцны барилгын эхний эзлжийн 117 өрхийн орон сууцны барилга ашиглалтад орох боломж бүрдэнэ.

Тус ажлын хүрээнд 3 байршилд гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтад 2,901.8 сая төгрөг шийдвэрлэгдэн бүтээн байгуулалтын ажил хийгдсэн.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төслийн хүрээнд 3 байршилд гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг зөвшилцсэн, 3 байршилд ус хангамж, ариутгах татуургын шугамын төлөвлөлтийн шийдэлд зөвлөмж, 2 байршилд дулаан, 3 байршилд цахилгаан хангамжийн техникийн нөхцөл шийдвэрлүүлсэн.

2002 оноос өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны А/28 дугаар захирамжийн хүрээнд 2024 оны 03 сарын 22-ны өдөр “Орон сууц болон олон нийтийн зориулалттай 18 барилгад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажлын даалгавар” батлуулан Үнэлгээний хороог 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Орон сууц, олон нийтийн зориулалт бүхий 18 барилгад худалдан авах ажиллагааны цахим системээр 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр олон нийтэд нээлттэй тендерийг зарласан боловч, амжилтгүй тендер шалгаруулалт болсон тул дахин 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр нээлттэй тендерийг олон нийтэд ил тодоор цахим системээр зарлаад байна.

ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭ:

Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санд оруулах, олон нийтэд нээлттэй болгоно.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө”-ний баримт бичгийг хүлээн авах, мэдээллийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан ebarilga цахим системд оруулан голуудын эргийн хамгаалалтын байгууламж, үерийн хамгаалалтын байгууламж, зам талбайн борооны ус зайлцуулах шугам сүлжээ, хөрсний усны шуурүүлийн байгууламж, гадаргын болон газрын доорх усны мониторингийн цооногууд, газар ашиглалт, үерийн эрсдэлтэй бүсүүдийн мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх ажлыг 2024 оны Газрын даргын дэргэдэх Захиргааны зөвлөлийн 01 дүгээр хурлаар танилцуулж, хүлээн авсан. Газрын uida.ub.gov.mn цахим сайтад инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний видео бичлэгийг байршуулсан.

Туул голын үерийн хамгаалалтын барилга байгууламжид хэсэгчилсэн засвар, шинэчлэлт хийнэ.

Туул голын эргийн болон үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын 1 дүгээр хэсгийн 1051 метр, 7дугаар хэсгийн 5065 метр ажлын зураг төсөл зөвшилцсэн.

Туул голын үерийн хамгаалалтын II, III, IV, V, VI хэсгүүдийн трассыг хянаж, санал өгсөн.

Сэлбэ сэргэлт төслийн хүрээнд үерийн хамгаалалтын барилга байгууламжид шинэчлэлт хийнэ.

Сэлбэ сэргэлт төслийн хүрээнд 44 км эргийн болон үерийн хамгаалалтын далан, 3 байршилд урсац тохируулга бүхий усан сан төлөвлөж ажлын зураг төсөл, ТЭЗҮ зөвшилцсөн. Тус ажлын хүрээнд Сэлбэ голын үеийн хамгаалалтын 2 км (s outlet орчим) далангийн засвар, өргөтгөл шинэчлэлтийн ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна.

Шинээр баригдах үерийн хамгаалалтын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулна. (Туул усан цогцолбор төслийн ТЭЗҮ боловсруулах)

Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх зөвлөлийн хурлын шийдвэрээр ажлын зураг төсөл боловсруулан, даалгаврыг батлуулан захиалагчид хүргүүлсэн. Үүнд:

- Баянгол дүүргийн 18 дугаар хороо, хөл бөмбөгийн талбайн үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгавар,
- Хан-уул дүүрэг 8 дугаар хороо 209 дүгээр цэцэрлэг орчмын үерийн далан сувгийн ажлын зураг төсөл боловсруулах даалгавар,
- Улиастай голын усан сан, үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгавар,
- Баянгол, Нарангийн үерийн хамгаалалтын сувгийн төгсгөл хэсгийн ажлын зураг төсөл боловсруулах даалгавар.

Улаанбаатар хөгжлийн корпорацад Туул усан цогцолборын ТЭЗҮ боловсруулах, нийслэлд хэрэгжүүлэх хөгжлийн төслүүдийн жагсаалтад оруулахаар танилцуулга бэлтгэн санал хүргүүлсэн.

Эрдэнэтолгой УС-15 орчмын үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний усны түвшин доошуулах шугамын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

Эрдэнэтолгой УС-15 орчмын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд тусган, хамгаалалтын зурvasыг баталгаажуулсан.

Замын ус зайлзуулах шугам, худгийн засвар, өргөтгөлийн ажил эхлүүлнэ.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/97 дугаартай тушаалаар Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 04/215 дугаартай албан бичгийн дагуу ус тогтдог 24 байршлын ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг Газрын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх зөвлөлийн 04 дүгээр хурлын шийдвэрээр батлуулан хүргүүлсэн.

Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.

Мянганы сорилтын сангийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа ус дахин цэвэршүүлэх үйлдвэр баригдаж байна. Үйлдвэрийн барилга угсралтын ажил хийгдэж байна.

Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагааны ажлын зураг төсөл, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.

Хаягдал ус дахин боловсруулах төслийн цэвэршүүлсэн усны ф700-1000 мм-ийн 10 км цэвэршүүлсэн усны шугам, насос станцын байршлын ажлын зургийн трассыг хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан. Ажлын зураг төслийг Икон консалтинг ХХК гүйцэтгэсэн. Үйлдвэрийн барилга угсралтын ажил хийгдэж байна.

Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн системийн барилга угсралтын ажил хийгдэнэ. (Хан-Уул дүүрэг)


Зайсан орчмын орон сууцны хороололд барих усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажлыг “Бат комплект” ХХК гүйцэтгэж байна. Зайсангийн гүүрийг шинэчлэх ажлын хүрээнд баригдаж байгаа гүүрэн байгууламжийн ажилтай уялдуулан “Мөнх консалтинг” ХХК-ийн боловсруулсан цэвэр бохир усны шугам хоолойг байршуулах ажлын зураг төслийг зөвшилцсөн.

Хан-Уул дүүргийн 11 хорооны нутаг дэвсгэрт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн систем (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг)-ийн угсралтын ажлыг эрчимжүүлэх, ашиглалтад оруулах асуудлаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа бөгөөд ажлын хэсэг Барилга, хот байгуулалтын яаманд байгуулагдсан. Шугамын барилга угсралтын ажлыг “Бат комплект” ХХК гүйцэтгэж байна.

Ариутгах татуургын “Туул-1” коллекторын 3, 4 ээлжийн угсралтын ажлыг үргэлжлүүлнэ.

Туул-1 коллекторын 3, 4 дүгээр ээлжийн барилгын зургийн өөрчлөлтийг Монхидро констракшн ХХК гүйцэтгэж байгаа боловч зургийн ажлыг баталгаажуулах ажил хийгдэхгүй байна. Улсын төсвийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд шугамын барилга угсралтын ажилд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх саналыг боловсруулан албан бичгээр хүргүүлсэн. Туул-1 коллекторын трасст орсон иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийн мэдээллийг гаргаж, ажлын зургийн өөрчлөлтөд тусгуулахаар саналаа зөвлөх үйлчилгээний байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлсэн, мөн ажлын хэсэгт танилцуулсан. Туул-1 коллекторын барилга угсралтын ажлын явц тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран бохир усны шугамын төлөвлөлтийн трасс, өөрчлөлтийн трассыг хотын мэдээллийн менежментийн санд оруулсан. Нийслэлийн 2024 оны төсөвт хөрөнгийг тусгуулахаар саналаа Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 01/01/1546 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Захиалагчийн хяналт тавьж байгаа Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас ирүүлсэн хөрөнгө шийдвэрлүүлэх саналыг үндэслэн Бохир усны Туул-1 коллекторт шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэхээр саналаа Сангийн яамны PIMIC программд илгээсэн.

Улаанбаатар хотын бохир усны Туул-1 коллекторын III, IV хэсгийн газар чөлөөлөлтийн зардал газрын суурь үнээр тооцсон байдал



Дамбадаржаа шинэ дэд төвийн 63 МВт-ын дулааны станцыг барьж ашиглалтад оруулна.

Дамбадаржаа дэд төвийн гадна инженерийн шугам сүлжээ, 63МВт-ын дулааны станцын ажлын зураг төсөл зөвшилцөж, хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. Гадна инженерийн шугам сүлжээ, дулааны станцын барилга угсралтын ажил хийгдэж байна.

Дэнжийн мянга дэд төвийн 50 МВт-ийн хийн болон дэвшилтээт технологи бүхий эх үүсвэр барьж байгуулна.

Дэнжийн 1000 дэд төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл зөвшилцөж, хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан. Дэнжийн 1000 хийн технологийн 93МВт-ын дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ нь Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021 оны V хуралдааны 01 дүгээр тэмдэглэлээр батлагдсан. Ажлын зураг төсөл 80% -тай, газар чөлөөлөлт 70 % -тай байна. Дулааны эх үүсвэрийн эскиз зургийг Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн 17 дугаар хурлаар хэлэлцүүлэн батлагдсан.

"Сэлбэ сэргэлт" төслийн ажлыг эхлүүлнэ.


Тус төслийн Барилга, хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга нарын хамтарсан дугаар №2023/09 тоот зургийн даалгавар батлагдсан. Үндсэн зургийн даалгаврын дагуу туслан гүйцэтгэгч нарын зургийн даалгаврыг боловсруулах ажилд санал өгсөн.

Сэлбэ сэргэлт төслийн автозамын трасс батлуулах ажлын хүрээнд санал өгч, төслийн ажлын хэсгийн хурал, зөвлөлдөх уулзалтад оролцсон. 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулагдсан Улаанбаатар хотын тогтвортой Зорчилт хөдөлгөөний стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээний семинаарт оролцож, санал зөвлөмж өгсөн.

Сэлбэ сэргэлт төслийн далан, зам гүүрний тохижилтын ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн Е3-0001/2024 дугаартай магадлалын дүгнэлтээр баталгаажсан.

"Сэлбэ сэргэлт төслийн авто замын гэрэлтүүлэг, тохижилтын цахилгаан хангамжийн ажлын зураг төслийг тус тус зөвшилцсөн.

"Сэлбэ сэргэлт" төслийн зураг төслийн ажилд хөндлөнгийн захиалагчийн хяналт тавьж оролцсон бөгөөд Зураг төслийн магадлалын нэгдсэн дүгнэлт эцэслэгдсэн тул манай газрын чиг үүргийн дагуу тухайн ажил дууссан. Захиалагчийн хяналтыг Барилгын хөгжлийн төв тавьж байгаа болно.



Шинэ тойрог зам, Яармаг хотын төвийн гол замын загвар зурийг батлуулна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 476 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын "Шинэ тойрог зам"-ыг барьж байгуулах төслийн бүрэлдэхүүн хэсэг болох Туулын авто зам, гүүрэн байгууламж болон Нисэхийн хурдны замыг Туулын авто замтай холбох авто зам


барьж байгуулахтай холбогдуулан Туул голын эргийн хамгаалалтын далан сувагтай уялдуулах ажлын хуралд 2 удаа оролцож санал өгсөн.


Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/860 дугаар захирамжаар Улаанбаатар хотын шинэ тойрог зам барих төслийн хойд хэсэг болох СХД-ийн 32 дугаар хороо, Баруун турууны Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Гачууртын зам, Баянзүрхийн гүүр хүртэлх авто зам, босоо чиглэлийн хоёр авто зам (СХД-ийн 2 дугаар хороо Нарангийн энгэрээс СХД-ийн 20 дугаар хороо, Сонсголонгийн зам Моносын турван замын уулзвар хүртэлх авто зам, ЧД-ийн 16 дугаар хороонд байрлах ЧД-ийн нийтлэг үйлчилгээний газраас СХД-ийн 20 дугаар хороо, Өнөр хорооллын гудамж, Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто зам) нийт 55км авто замын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын уялдаа, холбоог хангах, шаардлагатай мэдээ, мэдээллийг шуурхай солилцох, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүнээр орж ТЭЗҮ боловсруулахад шаардлагатай материал мэдээллээр хангаж ажилласан. Замын ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний ХЭТ авто зам ажиллаж байгаа бөгөөд замын трассын 3 хувилбарыг тус газарт урьдчилсан байдлаар танилцуулсан.

Туул авто замыг нүхтийн авто замын наадамчдын гудамжны авто зам дээгүүр барих 800м гүүний тулгуур таарсан мэдээлэл харилцаа холбооны сувагчлал шилжүүлэх ажлын зураг төслийг зөвшилцөж хот байгуулалт мэдээллийн санд оруулсан.


Яармагийн гол замын дагуух хоёр талын тусгах замын төлөвлөлтийн хүрээнд ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний тодруулга гаргаж ажилласан.

Шинэ тойрог зам болон Яармаг хотын төвтэй холбох ажлын хүрээнд Зам, тээвэр хөгжлийн яамны захиалгаар Туулын авто замыг Нүхтийн авто замтай холбох Наадамчдын авто зам дээгүүр барих 800 метр гүүрэн байгууламжийг зам замын байгууламжийн загвар зураг төслийг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 7 дугаар хурлаар хэлэлцүүлж, зохиогч аж ахуй нэгжтэй загвар зураг төслийг зөвшилцэн батлуулсан.





Бүгд Найрамдах Франц Улс /БНФУ/-ын Засгийн газрын нэн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин тээвэр нэвтрүүлэх төсөл”-ийн бүрэлдэхүүн хэсэг болох 2-р шугам (Баянгол дүүргийн 29 дүгээр хорооны нутаг дэвсгэр “Шинэ Сандэй худалдааны төв ХХК”-ийн баруун талаас Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр “Porsche Улаанбаатар төв”-ийн зүүн талд барихаар төлөвлөсөн урд буудлын барилга байгууламжийн МЗХ2024/00-078 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулсан.



Нийтийн тээврийн хүртээмж, төрлийг нэмэгдүүлнэ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд Олон Улсын стандартыг бүрэн хангасан Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барьж байгуулахаар шийдвэрлэсэн. Дээрх ажлын хүрээнд “Метро”-ний нэгдүгээр чиглэл болох Улиастайн гүүрнээс, (МОНОСЫН УУЛЗВАР)-Сонсголонгийн зам хүртэлх нийт 40

цооногийн 30 метрийн цооногт өртөж буй инженерийн шугам сүлжээний тодруулгыг 2024 оны 01-05/257 тоот албан бичгээр “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-т хүргүүлсэн.

Нийтийн тээврийн хүртээмж, төрлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд шаардлагатай тодруулгыг гаргаж санал өгсөн. Төмөр замын доогур хийгдэх нэвтрэх сувгийн ажлын хүрээнд ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний шийдэл гаргах ажлын хэсгийн хуралд оролцож санал өгсөн.

Авто замын өргөтгөл шинэчлэлийн ажлын хүрээнд ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төслийг З байршилд зөвшилцсөн.

“Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийн хүрээнд 4 байршлын нүхэн гарцын замын ус зайлцуулах шугамын одоогийн байдлын мэдээлэл бэлтгэж өгсөн ба төлөвлөлтийн шийдэлд санал өгсөн.

ЗОРИЛГО 2. ХУУЛИАР ХҮЛЭЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар, ажлын даалгавар боловсруулан батална.

Хот байгуулалтын баримт бичиг боловсруулалт, хэрэгжилт, Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдах барилга, авто зам, замын байгууламж, инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн даалгавар боловсруулах үйл ажиллагааг хэлэлцэх чиг үүрэг бүхий зөвлөлийн хурлыг 22 удаа нээлттэй зохион байгуулж, 512 асуудал хэлэлцэнээс 366 асуудал дэмжигдсэн. Хурлаас гарсан санал, тэмдэглэлийг баталгаажуулан www.uda.ub.gov.mn цахим хуудсанд байршуулав. 2024 оны хагас жилийн байдлаар:

- Архитектур төлөвлөлтийн даалгавар 433,
- Загвар зураг 368 хянан бүртгэж, баталгаажуулав.

Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн нийтийн эдэлбэр газрын тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батална.

- Тохижилтын ажлын загвар зургийг 42 байршилд хянаж, батлуулсан.

Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар батална.

- Архитектур төлөвлөлтийн даалгавар 24,
- Загвар зураг 24 зөвшилцөн батлуулсан.
- Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажилд санал өгч, 439 ажлын зураг төсөл зөвшилцсөн.

Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн нийтийн эдэлбэр газрыг дахин төлөвлөн зохион байгуулна.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/234 дүгээр захирамжаар “Урт цагаан жуулчны гудамжны тохижилтын ажил” арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд МЗХ2024/00-103 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулж, “Дээрээ тохижилт бүхий газар доорх зогсоол, үйлчилгээний цогцолбор барилга”-ын загвар зураг батлагдсан.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Гандантэгчэнлин хийд орчимд Нийслэлийн хот байгуулалтын цахим системд суурилсан олгогдсон барилга байгууламжийн Архитектур төлөвлөлтийн даалгавар, батлагдсан загвар зураг, барилгын ажлын зөвшөөрөл, тохижилтын ажлын

төлөвлөлтийн даалгавар, барилгажилтын судалгаа, хүн амын судалгаа, инженерийн шугам сүлжээний одоогийн байдал, газар чөлөөлөлтийн төсөөллийн үнэлгээ, Нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж төлөвлөх боломжтой байршил болон газар чөлөөлөлтийн төсөөллийн үнэлгээ зэрэг судалгаа, танилцуулгыг бэлтгэж, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанад 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/466 дугаар захирамжийн дагуу 120 байршилд гарааш буулгаж, газар чөлөөлж, тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Дээрх 120 байршилд 5 бүлгээр судалгааг боловсруулж 100 хувь төлөвлөлтийн шийдэл гаргасан. 120 байршилаас 81 байршилд Төлөвлөлтийн даалгавар батлагдсан, инженерийн дэд бүтэц хамгаалалтын зурваст төлөвлөлтийн даалгавар төлөвлөх боломжгүй 9 байршил, Авто зам, замын байгууламж болон Тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар шинээр 30 байршилд боловсруулж байна. Үүнд:

- Авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар 8 байршилд,
- Тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар 22 байршилд.

Барилга, байгууламж, тохижилт, авто зам, замын байгууламжийн загвар зураг батлах, хүчинтэй хугацааг шийдвэрлэнэ.

2024 оны хагас жилийн байдлаар 368 загвар зургийг хянан бүртгэж, баталгаажуулсан. Үүнд:

- Барилга байгууламжийн загвар зураг – 259,
- Тохижилтын ажлын загвар зураг – 85,
- Авто зам, замын байгууламжийн загвар зураг – 24.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн барилгажилтын төслийг хууль журам, норм ба дүрмийн дагуу батална.

Гэр хорооллын нутаг дэвсгэрт дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд хот байгуулалтын БНБД, стандарт мөрдүүлж, зөвлөмж, арга зүйгээр ханганд зураг төсөл зохиогч аж ахуй нэгжийн 6 барилгажилтын төсөл, загвар зургийг хянан баталсан.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах төслийн архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургийг хууль журам, норм ба дүрмийн дагуу батална.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн Архитектур төлөвлөлтийн даалгавар норм дүрмийн дагуу батлах хүрээнд хээрийн судалгааг хийж ажилласан. Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэгчээс ирсэн 2 загвар зураг хянан батлав.

Барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлтийг шийдвэрлэнэ.

Барилгын байгууламжийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх 17 хүсэлт ирснийг Нийслэлийн Ерөнхий архитекторт танилцуулан шийдвэрлэсэн.

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, талбай, хотхон хорооллыг нэршүүлэх, нэрэмжит болгох ажлыг зохион байгуулна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 06 дугаар тогтоолоор “Лондонгийн гудамж”, “Сүбээдэй баатарын гудамж” гэж шинээр нэршүүлсэн. Батлагдсан тогтоолыг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, бусад хүсэлт ирүүлсэн байгууллагуудад албан бичгээр хүргүүлж, MNS 5283:2022 “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага”-ын дагуу гудамжны хаягийн самбарыг байршуулах талаар мэдэгдсэн.

Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд Улаанбаатар цэцэрлэгт хурээлэнд нэр олгох асуудлаар 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр нэрийн комиссын хурлаар хэлэлцүүлж, саналаа Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулан, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн. 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр тогтоолын төслийг нийслэлийн удирдлагуудад танилцуулан, хяналтын хуудсаар баталгаажуулж, 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Зөвлөлийн хуралд тус тус танилцуулсан бөгөөд одоо Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр хүлэгдэж байна.

Байгууллагын www.uda.ub.gov.mn цахим хуудсанд гудамж талбайн нэршлийн ерөнхий мэдээлэл, шинээр нэршүүлсэн 2 гудамжны байршил зэргийг цаг үеийн мэдээ буланд байршуулж, олон нийтэд мэдээлсэн.

Хот байгуулалтын мэдээллийн сангийн гудамж, зам талбайн мэдээллийн санг шинэчлэв.

Барилга байгууламжид хаяг дугаар олгох, мэдээллийг бүрдүүлэх, орон зайн дүн шинжилгээ хийх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

Яармаг дахь Нэгдсэн үйлчилгээний нэгдсэн төв edoc албан бичгийн цахим систем, emongolia, eBarilga геопорталаар иргэн өөрөө хүсэлтээ илгээсэн зэрэг эх сурвалжуудаар ирүүлсэн барилга мэдээллийн санд бүртгүүлж, хаяг дугаар авах нийт 635 иргэн, хуулийн этгээдийн 832 барилгад шинээр, 75 барилгад дахин тодорхойлолт олгов.

Барилга байгууламжийн тэг тэнхлэгийн актын мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэж, өгөгдөл, мэдээллийг бүрдүүлнэ.

Барилга, байгууламжийн тэг тэнхлэгийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгөх 236 иргэн, хуулийн этгээдийн 187 блок барилга байгууламжийн актыг хүлээн авч нийслэлийн Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэн, 152 акт үйлдэж өгөв.

Гүйцэтгэлийн байр зүйн зургаар мэдээллийн санг бүрдүүлэн, баяжуулна.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний 525 байр зүйн зураг хүлээн авч хот байгуулалтын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг 102.1 га талбайгаар шинэчлэн баяжуулж, 341 акт үйлдсэн.

211 иргэн, хуулийн этгээдийн хаяг дугаар авах хүсэлтээр 63 га талбайн байр зүйн зургаар шинэчилсэн.

Хот байгуулалтын мэдээллийн сан дах зурган болон тоон мэдээ, мэдээллээр үйлчлэх, гэрээ байгуулж хамтран ажиллана.

Албаны нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах гэрээний дагуу 2 байгууллагад байр зүйн 154ш планшет зураг, Газар зүйн мэдээлэл солилцох гэрээний дагуу 3 байгууллагад 23 төрлийн орон зайн мэдээллийг, албан бичгээр болон бусад хүсэлтээр 19 байгууллагад давхардсан тоогоор нийт 113 төрлийн мэдээ, мэдээллийг өгөв.

Инженерийн шугам сүлжээний зурган мэдээлэл авах 64 хүсэлтийг хүлээн авч тоон байдлаар /*dwg/ 97 га талбайн байр зүйн зураг, А3 форматтай хэвлэмэл байдлаар 7ш, А4 форматтай хэвлэмэл байдлаар 23ш зураг өгөв.

Орон зайн мэдээллийн дэд сангийн өгөгдлийг бүрдүүлэн, шинэчилнэ.

Шинээр хаяг дугаар авсан 832 барилгын 20-40 төрлийн мэдээллээр хот байгуулалтын мэдээллийн сангийн барилгын мэдээллийн санг баяжуулав.

Шинээр нэршүүлсэн 2 гудамжны мэдээллээр гудамж, зам талбайн мэдээллийн санг шинэчлэв.

Нийслэлийн 204 хорооны байрны мэдээллийг нэгтгэж, орон зайн мэдээллийн сан үүсгэж, хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэв.

Соёлын өвийн төв, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газруудаас ирүүлсэн мэдээллүүдээр нийслэлийн хот байгуулалтын суурь мэдээллийг баяжуулсан.

Нийслэлийн Байгаль орчны газраас ирүүлсэн ой сан, голын онцгой хамгаалалтын бүсүүдийн мэдээллийг тоон байдлаар хүлээн авч хот байгуулалтын суурь мэдээллийн давхаргад байршуулсан.

Нийслэлийн Замын хөгжлийн газар ирүүлсэн авто замын төлөвлөлтийн трассын мэдээллийг хүлээн авсан.


Байгууллагын цахим хуудасны мэдээ мэдээллийг шинэчлэх, хөгжүүлэлтийг тоогтмол хийх, сайжруулах, тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажиллана.

<http://uda.ub.gov.mn> цахим хуудсыг MNS6285:2017 Төрийн байгууллагын вэб сайтад тавигдах шаардлага, стандартын дагуу хөтөлж, 10 төрлийн 140 мэдээ мэдээллийг шинэчилсэн. Үүнд:

- Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээ – 3,
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт – 2,
- Санхүүгийн мэдээ – 7,
- Мэргэжлийн зөвлөлийн хурлын мэдээ – 40,
- Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон мэдээ – 4,
- Хүний нөөцийн мэдээ – 10,
- Ирсэн, явсан бичгийн мэдээ – 12,
- Цаг үеийн мэдээ – 10,
- Батлагдсан стандарт баримт бичиг – 52.

Одон орон геофизикийн хүрээлэнтэй газар хөдлөлтийн чиглэлээр хамтран ажиллана.

Одон орон, геофизикийн хүрээлэнгээс 2021 оны 170 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Хүчтэй газар хөдлөлтийн баллыг тодорхойлох багаж, төхөөрөмжийг Улаанбаатар хотын 4 бүсэд суурилуулан урт хугацаанд хамтран хэмжилт, судалгаа хийв.



Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөр, зээл тусlamжаар хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн ажлын даалгавар боловсруулах, ажлын зураг төслийг хянах, зөвшилцөх, хэрэгжилтэд хяналт тавина.

Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага хооронд байгуулсан Хамтран ажиллах тухай “НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ 2023-2027” батламжийн дагуу Хүн амын нутагшил суурьшлын хөтөлбөрийн Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох сангийн буцалтгүй тусlamжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд хийгдэх Сонгинохайрхан дүүргийн 26, 27, 4, 5 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 15, 16, 18, 20 дугаар хороодын нутаг дэвсгэр буюу Толгойт болон Бэлхийн голын байнгын халиа, тошин, үер усанд өртдөг хэсэгт голын эргийн хамгаалалт болон үерийн хамгаалалтын байгууламж барих, моджуулах, өвлүйн цагт халиа үүсэхээс сэргийлэх үерийн хамгаалалтын суваг, хөрсний усны түвшин бууруулах шугам сүлжээ, хөв цөөрөм байгуулах ажлын хэрэгжилтийг хангах зураг төсөл, барилга угсралтад шаардлагатай арга хэмжээт шуурхай зохион байгуулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, зөвлөх шалгаруулах үнэлгээний хороо, техникийн шийдэл зөвшилцөх 2 удаагийн хурал уулзалтыг зохион байгуулж санал өгсөн.

Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр 3 байршилд 2ф300/400мм голчтой 5.2хос.км дулааны шугам, Дэлхийн банкны санхүүжилтээр 2ф250/300/400/500/800мм голчтой 4,5хос.км дулаан шугамыг 8 байршилд, нийт 9,7 хос.км төвлөрсөн дулаан хангамжийн магистраль шугамын ажлын зураг төсөл зөвшилцөж, хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд байршуулсан.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгах гадна инженерийн шугам сүлжээний 9 төсөл арга хэмжээний 106,486 сая төгрөгийн саналыг хүргүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгөөр оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв Улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын жагсаалтад холбогдох шугам сүлжээний ажлуудын саналыг Сангийн яамны РIMIS сүлжээнд оруулсан.

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/52 дугаар тушаалаар Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн тогтолцоог бэхжүүлэх, үндэсний болон орон нутгийн түвшинд уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй үйлчилгээ бий болгох зорилтыг хэрэгжүүлэх 2024-2028 оны дунд хугацааны төлөвлөгөөнд тусгуулах ажилд ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын саналыг өгсөн.

Хот суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөх, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, асуудлыг зохион байгуулна.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн явц, тулгамдаж буй асуудлын талаарх танилцуулгыг бэлтгэв.

2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Нийслэлийн 1 дүгээр Орлогч дарга П.Сайнзориг, Газрын дарга Г.Батзориг, тус газрын Ерөнхий архитекторын ажлын албаны дарга М.Шижирбаяр, Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтсийн дарга М.Мэндсайхан нар Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны 21, 22 дугаар байруудыг буулган дахин барилгажуулах төсөл хэрэгжүүлэгч “Уран проект” ХХК болон тухайн байрны үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч мөн Баянгол дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай 35, 36 дугаар байрны үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч нартай НЭДТГ-ын хурлын зааланд дахин төлөвлөлтийн ажлын талаар хуралдсан. Хурлаас төсөл хэрэгжүүлэгч “Уран проект” ХХК-н 21, 22 дугаар байрны үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигчидтэй уулзалт зохион байгуулж, Хяналтын хорооны шийдвэрийг ирүүлэх чиглэл өгсөн.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журмын 7.4, 7.7-д заасныг үндэслэн иргэдийн саналыг тусгаагүй график төлөвлөгөө ирүүлсэн, батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явагдахгүй, сууц өмчлөгч иргэд болон хяналтын хорооноос төсөл хэрэгжүүлэгчийг дэмжихгүй зэрэг үндэслэлээр дараах 2 байршилд төсөл хэрэгжүүлэгчийн эрхийг цуцалсан. Үүнд:

- Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны Залуус 1, 2, 5, 8, 9 дүгээр байрыг буулган барилгажуулах төсөл хэрэгжүүлэгч "И Си Си" ХХК,
- Баянгол дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 35, 36 дүгээр байрыг буулган барилгажуулах төсөл хэрэгжүүлэгч "Уран проект" ХХК

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоно.

Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм"-ийн хэрэгжилтийн хүрээнд барилгын ажлын зөвшөөрөл авах 569 хүсэлтийг хүлээн авсан. Үүнд:

- Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг олгосон 367,
- Судалж байгаа 57 хүсэлт,
- Материалын бүрдэл дутуу, шаардлага хангахгүй 147 хүсэлтийг буцааж хуулийн хүрээнд хариу өгч шийдвэрлэсэн.

Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон байдал:

Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалттай 67 барилга байгууламж:

- Сургууль - 11
- Цэцэрлэг - 18
- Эмнэлэг - 5
- Олон нийтийн барилга - 33

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай 253 барилга байгууламж:

- Барилга - 135
- Цахилгаан хангамж - 100
- Барилга буулгах - 13
- Шугам сүлжээ – 5

БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛ



Нийслэлийн нутаг дэвсгэрт Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх нийгмийн болон инженерийн дэд бүтцийн ажлын барилга, байгууламжийн угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоно.

Нийслэлийн нутаг дэвсгэрт Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн барилга угсралтын 47 ажилд:

- Инженерийн шугам сүлжээ - 15
- Гудамж замын гэрэлтүүлэг - 3
- Цахилгаан хангамж – 29

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олгосон Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн хүрээнд Барилга, байгууламжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, орчны аюулгүй байдал болон хөдөлмөр хамгаалалтыг хангуулж ажиллана.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 135 иргэн, хуулийн этгээдэд "Барилгын талбайн түр хашаа MNS5414:2004" стандартад заасны дагуу инженерийн бэлтгэл арга хэмжээг хангуулж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх талаар Газраас гаргасан Зөвлөмжийг хүргүүлэв.

Барилгын ажлын явцад үүссэн хот байгуулалт, төлөвлөлттэй холбоотой зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэн ажиллана.

Нийслэлийн нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүйгээр барилгын ажил гүйцэтгэж байгаа 22 иргэн, хуулийн этгээдэд илэрсэн зөрчлийг арилгах талаар албан шаардлага, мэдэгдэл хүргүүлж, илэрсэн зөрчилд холбогдох арга хэмжээ авч ажиллах талаар холбогдох байгууллагад албан бичиг хүргүүлсэн.

Барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэн барих, буулгах ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд оруулж, цахим архив үүсгэж ажиллана.

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон 367 барилга байгууламжийн хаяг байршил, захиалагч, зураг зохиогч, гүйцэтгэгчийн мэдээллийг Хот байгуулалтын мэдээллийн менежментийн eBarilga.ub.gov.mn нэгдсэн системд бүртгэлжүүлэн, цахим архив үүсгэв.

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олгосон Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн хүрээнд хот байгуулалтын мэдээллийн сангийн зураглал, мэдээлэл бэлтгэж ажиллана.

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олгосон Барилгын ажлын зөвшөөрөлтэй барилгын мэдээллийг eBarilga цахим систем, Qgis программ тулгуурлан pdf, kmz өргөтгөлөөр зураглал бэлтгэв.

Газрын эрхлэн явуулж буй үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, газрын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай холбогдох дүрэм, журмын төслийг боловсруулж, санал өгнө.

Газрын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд нийт 13 албан бичгээр санал хүргүүлэв. Үүнд:

- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1 тогтоолын төсөл,
- Нийслэлийн Засаг даргын 4 захирамжийн төсөл,

- Газрын даргын А тушаалын төсөл 22, Б тушаалын 34 төсөл

Салбарын хэмжээнд мөрдөгдөх болон бусад 4 хууль тогтоомж, 5 журам, 25 стандарт, 3 нормд санал хүргүүлсэн.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хууль болон дагалдан гарсан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан шинээр дүрэм, журам, шийдвэрийн төсөл боловсруулж батлуулна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1381 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль болон дагалдан гарсан хуулиудад тусгагдсаны дагуу шаардлагатай 8 баримт бичгийг холбогдох байгууллагатай хамтран боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Газрын даргын 2023 оны А/43 дугаар тушаалаар байгуулж, 8 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан дүрэм, журам, тогтооны төслийг боловсруулсан.

Нийтийн эдэлбэр газарт авто зогсоол төлөвлөх 5 заалт бүхий журмын төсөл боловсруулж, Нийслэлийн Удирдлагуудаас болон Нийслэлийн Авто замын газраас санал авч, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 21 дүгээр хурлаар хэлэлцүүлсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барьж, 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр батлагдсан.

Нийслэл хотын эдэлбэр газрыг тогтооход санал өгнө.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд нийтийн эдэлбэр газрыг дахин төлөвлөн барилгажуулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Нийслэл хотын эдэлбэр газрын саналыг Хот төлөвлөлт судалгааны институтэд ОНӨААТҮГ-т хүргүүлсэн.

Нийслэл хотын эдэлбэр газрын хэмжээг Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт 35206.0 га, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепцид 47044.4 га, Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд 120802.7 га газар байхаар газрын хил заагийг тогтоосон байна. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хил заагд тусгай хамгаалалттай газар нутгийн хил зааг, ойн сан бүхий газрууд хамрагдахгүй. Иймээс Нийслэл хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоосны үндсэн дээр Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл тогтоо шалгуур үзүүлэлтийг баталж улмаар Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэлийн дүрмийг боловсруулах ажил хийгдэх боломжтой байх тул Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа дээрх ажлуудыг шат дараатай хэрэгжүүлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01-10/177 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

Дагуул хот байгуулах дүрэм, эдийн засгийн тусгай бус байгуулах ажилд санал өгнө.

“Алсын харах 2050” Урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Улаанбаатар хотын Дагуул, хаяа, хот тосгодын төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж буй байршуудаас эхний ээлжид Буянт-Ухаа, Налуу-Ухаа, Аргалант, Эмзээлт дагуул хот байгуулах эдэлбэр газар, хэмжээ, байршлыг судалж дагуул хот, эдийн засгийн тусгай бус байгуулах суурь судалгааг хийсэн. Судалгаанд үндэслэн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 9000 га талбайд хүлэмжийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр, Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5,650 га талбайд тээвэр ложистик, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр тус тус эдийн засгийн тусгай бус байгуулах тухай санал боловсруулж, Засгийн газрын тогтоолын төсөл, төслийн товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулж яамдаас санал авч, ирүүлсэн саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, эдийн засгийн тусгай бус байгуулахаар шийдвэрлэсэн.

Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтын хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоож, хотын бүтээн байгуулалт, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогыг тодорхойлох зорилго

бүхий Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг 6 бүлэг, 29 зүйлтэйгээр боловсруулж, УИХ-ын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан.

Байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой хот байгуулалтын гэрээ, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төсөлд оролцогч талуудтай гэрээ байгуулах, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, дүгнэх асуудлыг зохион байгуулна.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” А/443 дугаар захирамжаар тус газрын Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтсийн чиг үүрэг болон Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөлд оролцогчдын хооронд байгуулсан гурван тал гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих чиг үүрэг Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт шилжсэнтэй холбогдуулан батлагдсан 901 гурван талт гэрээ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраар батлуулах 3 өрхийн 5 хувь гурван талт гэрээг тус тус Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт шилжүүлсэн.

Хот байгуулалтын дотоод үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдтэй 7 гэрээ шинээр байгуулж, зөвлөх үйлчилгээний 4 гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавин ажиллав.

Газрын хэмжээнд дотоод хяналтыг зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллана.

Газрын даргаар 2024 онд Дотоод хяналт шалгалтын ажлын 13 ажил төлөвлөн батлуулав. Төлөвлөгөөний дагуу Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний бүрдүүлбэр, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийх дотоод хяналт шалгалтын ажлын 2024/01 дугаартай удирдамж Газрын даргаар батлуулав. Удирдамжийн дагуу Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний бүрдүүлбэрт хяналт шалгалт хийх бөгөөд Барилгын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан “Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээллийг тусгасан эсэх, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор баталсан Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийг мөрдүүлж ажилласан эсэх, Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олголтой холбоотой өргөдөл гомдол, албан бичгийн шийдвэрлэлтийн чанар, хугацааг шалгаж 2023 оны шалгалтын ажилтай харьцуулах мөн хүчингүй болон түдгэлзүүлсэн Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд дүн шинжилгээ хийж байна.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн ажил үйлчилгээ, мэргэжил ур чадварын талаар гаргасан 51 өргөдөл, гомдлыг хууль, дүрэм, журам, барилгын норм дүрэм хангасан эсэх шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж Албаны шалгалт хийж хариу өгч шийдвэрлэв.

Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрддөг стандартыг хангуулж, мөрдлөг болгон ажиллана.

Нийслэлийн Ерөнхий архитектораар батлагдаж буй 445 төлөвлөлтийн даалгавар болон 368 загвар зурагт өдөр тутамдаа хяналт тавин Ерөнхий архитекторын ажлын албаны дардсаар баталгаажуулан бүртгэлийг хөтлөв.

Барилгын тухай, Газрын тухай, Хот байгуулалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, норм, стандарт, дүрэм, журмыг Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаа, барилгын ажлын зөвшөөрөл олгох нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллав.

2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2024 оны 05 дугаар сарын 27-оос 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл Улаанбаатар хотын орон сууцны хорооллын дундах орц, гарцтай

холбоотой зөрчлийг арилгаж, орц, гарц гаргах ажлыг газар дээр нь судалгаа хийж шийдвэрлэх, ажлын удирдамж гарган тус газраас 70 албан хаагч, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас 28 албан хаагч, нийт 98 албан хаагч 10 багт хуваагдан судалгаа хийж, шаардах хуудас өгч ажиллав. Төвийн 6 дүүрэгт хотхон, хорооллын дунд 3-5 хоногийн хугацаатай шаардах хуудас өгч, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангулан ажиллав. Үүнд:

- Явган болон авто замын орц, гарц хаасан, явган хүний зорчих хөдөлгөөнд саад болсон, буулгах шаардлагатай 68 байршлын 4367м хашаа;
- Стандарт хангуулах, сайжруулах шаардлагатай 29 байршлын 3227м түр хашаа;
- Зорчих хөдөлгөөн хаасан 31 хаалт, 36 объект чөлөөлөх.

Хууль, шүүхийн байгууллагад нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Ерөнхий архитектор болон Газрын даргын шийдвэртэй холбоотой эрх зүйн маргаанд итгэмжлэлээр оролцоно.

Иргэн, хуулийн этгээдийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг даргад холбогдох 25, Нийслэлийн Ерөнхий архитектор холбогдох 5, тус газарт холбогдох 86 маргаанаас захиргааны 100, иргэний хэргийн 7 маргаанд холбогдох материалын судалж тайлбар гаргах, нотлох баримт хүргүүлэх, хэргийн материалтай танилцах, газрын үзлэг хэмжилтэд оролцох, гэрч асуухад байлцах зэрэг ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр 117, нэхэмжлэгчээр 1, Үүнээс анхан шатны шүүхийн 68 хуралдаан, давж заалдах шатны 9 шүүх хуралдаанд оролцож ажиллав. Нийт 117 хэрэг хянан шийдвэрлэх шатандаа байна. Он дамжсан 91, тайлант онд гардаж авсан 26 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаагаас тухай онд 14 хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэв.

Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоолоор газрын зарим чиг үүргийг Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт шилжүүлсэнтэй холбоотойгоор захиргааны хэргийн 3 маргаан, иргэний хэргийн 1 маргааны Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт шилжүүлэв.

Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг хянган ажиллаж, тайлагнана.

Бодлогын баримт бичгийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний газарт албан бичгээр болон цахим системээр сар бүр тайлагнан ажиллав. Үүнд:

- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт - 62.5%
- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт - 95%
- 150000 айл орон сууц үндэсний хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилт - 67%
- Монгол Улсын хөгжлийн 2023, 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт - 100%
- Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичиг - 50%

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар, 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцсэн. Нийслэлээс Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг нар оролцож, тайлангуудаа амжилттай хамгаалсан.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар болон 2024 оны сар бүрийн хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний газарт 2024 оны 01/01/146 тоот албан

бичгээр болон mandakh@ulaanbaatar.mn,tungalag.o@ulaanbaatar.mn цахим системээр тайлагнан ажиллав.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллана.

Газрын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж, газрын uda.ub.gov.mn цахим хуудас дээр байршуулах газрын тайлан, биелэлт, мэдээ мэдээллийг байршуулав.

Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээлэл, мэдээллийг ашиглахад хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, хүн, хуулийн этгээд хуулиар хязгаарлалт тогтоогоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлж, цахим хуудасны мэдээллийн ил тод байдлыг хангуйлж Нийслэлийн иргэдийн Төлөөлгөгчдийн Хурлын “Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн хэрэгцээний авто зогсоолыг барьж байгуулах, төлөвлөх тухай”, “Цэцэрлэг, ногоон байгууламж, авто зогсоолын шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгөд нэмэгдүүлсэн хувиар албан татвар ногдуулах журам”-ын тогтоолын төслийг тус тус байгууллагын цахим сайт болох uda.ub.gov.mn болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ulaanbaatar.mn цахим сайтад байршуулж иргэдээс нээлттэйгээр санал авсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байгууллагын жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, аудитын зөвлөмжийн биелэлт, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд тайлагнаж нийт 70 мэдээллийг сар бүр shilendans.gov.mn сайтад оруулж ил тод байдлыг ханган ажиллав. Тайланг улирал бүр илгээсэн.

Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоол Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох үнэлгээг 2024 оны 01/01/267 тоот албан бичгээр хүргүүлэв.

Callpro ХХК-тай хамтран иргэн, хуулийн этгээдэд газраас үзүүлж буй үйлчилгээ, албан бичиг, өргөдөл гомдлын талаарх мэдээллийг түргэн шуурхай дуудлага бүрийг алдахгүй утсаар хүргэх Операторын үйлчилгээг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн Callpro үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж дуудлага бүрд түргэн шуурхай хариу өгч ажиллав.

Хот байгуулалтын баримт бичиг боловсруулалт, хэрэгжилт, Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдах барилга, авто зам, замын байгууламж, инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн даалгавар боловсруулах үйл ажиллагааг хэлэлцэх чиг үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн хурлыг 22 удаа нээлттэй live хэлбэрээр зохион байгуулан ажилласан.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шил” ажиллагааны хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн 22 хурлыг иргэд, олон нийтэд нээлттэйгээр цахим хаягаар шууд дамжуулан ажиллав.

Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг тайлагнана.

Барилга, хот байгуулалтын Сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Зам тээврийн хөгжлийн Сайд, Эрчим хүчний Сайд нартай Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний төсөлд тусгах саналаа цахим системээр (choijoontan@gmail.com, Orgilsogtslohe@gmail.com, B.Enkhmandakh@gmail.com) болон албан бичгээр хүргүүлэв.

Барилга, хот байгуулалтын Сайдын албан даалгавар (Нийслэлийн хэмжээнд барилга, хот байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөний биелэлт)-ын хэрэгжилтийг 2024 оны 01-01/676 албан бичгээр хүргүүлэв.

Барилга, хот байгуулалтын яаманд Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах богино, дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 01-01/621 тоот албан бичгээр хүргүүлэв.

Барилга, хот байгуулалтын Сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Зам тээврийн хөгжлийн Сайд, Эрчим хүчний Сайд нартай Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захиргачийн 2024 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хагас жилийн хэрэгжилтийг 2024 оны 01-01/290 дугаартай албан бичиг болон цахим хаягаар хүргүүлэв.

Газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, хүний нөөцийн ил тод байдлыг хангаж ажиллана.

Газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг (стратегийн 9 зорилтын хүрээнд 20 арга хэмжээ) 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Газрын үйл ажиллагаатай холбоотой А тушаал 40, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 54, нийт 94 тушаалыг боловсруулан баталгаажуулж, дотоод сүлжээнд цахимаар байршуулан тушаалын бүртгэл хөтлөн, хэрэгжилтийн мэдээг гарган ил тод байршуулав. Нийт 94 захиргааны шийдвэрийн хяналтын дагалдах хуудас хөтлөн, хувийн хэргийг бүрдүүлэв. Ажлаас чөлөөлөгдсөн 14 албан хаагчийн, шилжин болон шинээр ажилд томилогдсон 56 албан хаагчийн мэдээллийг газрын цахим хуудсанд байршуулав. Z:\0.KNOT BAIGUULALT, KHUGJLIIN GAZAR\12. GAZRIIN DARGIIN TUSHAAL\2024

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо, цахим системд шинэчлэн баталсан төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, шинэчлэн тогтоосон албан тушаалын цалин, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, албан хаагчдын ажилласан жилийн түүхийг албан хаагчийн хамтаар мэдээллийг бүрэн гүйцэт, үнэн зөв оруулж тайлагнав. (идэвхтэй 109 албан хаагч, ажиллахгүй байгаа 157 нийт 266 албан хаагчийн мэдээлэл)

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны оны 600 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу төрийн албан хаагчийн анкетыг шинэчилсэн загвараар гаргуулан хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрдүүлэв. (14 албан хаагч)

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын цахим системд Газрын даргын 2024 оны "Албан хаагчдын албан тушаалын цалин нэмэгдлийг шинэчлэн тогтоо тухай" Б/08 дугаар тушаал (75 албан хаагчийн), Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоо тухай" 128 дугаар тогтоолоор баталсантай холбогдуулан Газрын даргын "Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын цалинг батлах тухай" Б/22 дугаар (69 албан хаагчийн), "Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалинг батлах тухай" Б/23 дугаар тушаалын (8 албан хаагчийн) дагуу давхардсан тоогоор 152 албан хаагчийн цалингийн мэдээллийг оруулж, өөрчлөлт хийв.

Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын 8 ажлын байрны 12 сул орон тоог нөхөхөөр Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан журмын дагуу сонгон шалгаруулалт явуулах захиалгыг холбогдох бүрдлийн хамт Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01-01/525 дугаар албан бичгээр хүргүүлэв. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан нээлттэй сонгон шалгаруулалтаар дээрх ажлын байр нөхөгдөөгүй.

2023 оны 11 дүгээр сард нэр дэвшин томилогдсон 3 албан хаагч, 2024 онд бүтэц зохион байгуулалттай холбоотой Хотын стандарт, хяналтын газраас шилжин ирсэн 2 албан хаагчийт 5 албан хаагчийг тангараг өргүүлэхээр Нийслэл дэх салбар зөвлөлд судалгаа, холбогдох баримт бичгийн хамтаар 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлэв.

Улсын Их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн жинхэнэ албан хаагчид албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг нэгж, албан хаагчдад танилцуулан, 2024 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 01-01/355 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/369 дүгээр захирамжаар 33 албан хаагчийн зэрэг дэвийг шинэчлэн тогтоосон. (20 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах, шинээр 13 албан хаагчид) Z:\0.KNOT BAIGUULALT, KHUGJLIIN GAZAR\8. HUNII NUUTSIIN MEDEELEL\5. 2024\5. ZEREG DEVIIN ZAHIRAMJ

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан журмын дагуу Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 86 албан хаагч батлуулж, төрийн үйлчилгээний 14 албан хаагч Хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулалт олгох журам”-ын дагуу 29 албан хаагчид албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж, албан үүргийг хавсран гүйцэтгэсний хөлсийг цалингийн 40 хувиар тооцож олгов. (2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр 13 албан хаагч албан үүргийг үргэлжлүүлэн түр орлон гүйцэтгэх шийдвэрийг дуусгавар болгов)

Төрийн албаны тухай хууль болон Газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 19 албан хаагчид 31,167,000 төгрөгийн тэтгэмж, цалинтай чөлөөг 6 албан хаагчид (55 ажлын хоног), цалингүй чөлөөг 5 албан хаагчид (61 ажлын хоног) тус тус Газрын даргын тушаалаар (4-өөс дээш хоногийн захиргааны чөлөө) олгов. W:\2024\5. Hunii nuutsiin hutulbur\TAZ & SALBAR ZUVLUL_TAJX-iin NUUTSIIN MEDEE & BUSAD TAILAN MEDEE

Монос групптэй хамтран “Эрүүл биед саруул ухаан оршино” өдөрлөгийг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр ажлын байранд зохион байгуулж 61 албан хаагчийг цус, шээсний ерөнхий шинжилгээнд хамруулж, 6 төрлийн үзлэгт оношилгоонд хамруулав. Z:\0.KNOT BAIGUULALT, KHUGJLIIN GAZAR\8. HUNII NUUTSIIN MEDEELEL\5. 2024\9. ERUUL MENDIIN UDURLUG 2024.01.30

2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар баталсан орон тооноос 109 албан хаагч байгаагаас 93 албан хаагч ажиллаж, хүүхэд асрах чөлөөтэй 16 албан хаагч байна.

Төсөө, санхүү, хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөн, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханггуулж, өр авлага үүсгэхгүй ажиллана.

Үндсэн үйл ажиллагааны орлого 30.0 сая олохоос 44.1 сая төгрөг олж 14.1 сая төгрөгөөр давуулан биелүүлээд байна. Орлогыг задлан авч үзвэл:

- барилгын ажлын зөвшөөрөл 7.5 сая төгрөг,
- гэрчилгээний сунгалт 0.6 сая төгрөг,
- дугаарын үнэ 23.7 сая төгрөг,
- тодорхойлолтын үнэ 0.9 сая төгрөг,
- зургийн үнэ 7.7 сая төгрөг,
- барилгын чанарын дүгнэлт 3.1 сая төгрөг,
- архивын лавлагаа 0.6 сая төгрөг тус тус олсон.

Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр гаргаж дээд газарт хүргүүлж хянуулсан. Санхүүгийн 2023 оны жилийн эцсийн тайланг гаргаж Нийслэл дэх Төрийн аудитын газраас аудит хийлгэж зөрчилгүй санал дүгнэлт авсан.

Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсээрээр 2024 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж ажиллана.

Улс, Нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, явц, үр дүнгийн мэдээг нэгтгэн 2023 оны 01/537 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

Сангийн яамнаас боловсруулсан Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.28 дахь заалтад заасан ногоон худалдан авах ажиллагааны тодорхойлолтод нийцүүлэн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийтлэг худалдан авдаг бараа, бүтээгдэхүүний ногоон шалгуур үзүүлэлт бүхий жишиг техникийн тодорхойлолтын төсөл болон холбогдох зааварт санал өгөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлэв.

Хөрөнгө оруулалтын барьцаа дансны мэдээг гаргаж дээд газарт хүргүүлсэн. Барьцаа дансанд 9 ажлын 241.0 сая төгрөг байснаас 4 ажлын 44.6 сая төгрөгийг олгосон.

"Тохижилт бүтээн байгуулалтын жилийн хүрээнд тодорхой ажил санаачилж, төлөвлөгөө гарган ажиллана.

Нийслэлийн 2024 оны зорилтод "Тохижилт бүтээн байгуулалтын жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1 дүгээр улирлын биелэлтийг Улаанбаатар хотын Захиргачийн ажлын албанд 2024 оны 01-01/835 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

2024 оныг "Тохижилт-Бүтээн байгуулалтын жил" болгон зарласантай холбогдуулан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захиргач "Барилгын салбарын бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт уулзалтыг нийслэлд үйл ажиллагаа явуулж буй барилгын салбарын бизнес эрхлэгч, инженерийн байгууллагын төлөөлөл, иргэн, хуулийн этгээдийн удирдлагуудтай 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 09:00-12.00 цагийн хооронд Монголын Хүүхдийн ордонд зохион байгууллаа.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1336 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээвэр Метроны Техник эдийн Засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын дагуу Амгалангаас Моносын уулзвар хүртэлх Метроны трассын дагуу 100м хамгаалалтын зурвасыг татан өртөж буй баригдсан барилгын мэдээллийг гаргав.

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжээс захиалгатай хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын зорчилт хөдөлгөөний стратеги төлөвлөгөөнд санал өгч, танилцуулга уулзалтуудад оролцон мэдээллээр хангаж ажиллав.

Гэр хорооллын бүсийг дахин төлөвлөн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Орон сууцны бодлогын газраас зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж, 2024 оны 03/301 дугаар Зөвлөмж хүргүүлэх албан бичиг ирүүлсний дагуу 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр №НХААГ202311392/01 дугаар бүхий "Сэлбэ дэд төв" орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл, Олон Улсын зөвлөх үйлчилгээ, зураг төсөл боловсруулах гэрээг "ББСМО" ХХК-тай байгуулсан. Гүйцэтгэгч компанийд батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зурган болон тоон мэдээллийг 2024 оны 02/1111 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Улаанбаатар хотод байгаа нийт 297 хатуу түлшний зуухын 45 байршлыг хийн түлш рүү шилжүүлэхээр Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газраас ажлын хэсэг гаран хамтран ажиллаж байна.

Нийслэлийн иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04”-д заасан хүн амын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршуудад хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, зам, замын байгууламж, тохижилт, ногоон байгууламж, нийтийн эзэмшилийн зам талбай барихаас бусад зориулалтаар шинээр газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх олгох, шилжүүлэх, талбайн хэмжээ, зориулалт, эдэлбэрийн хэлбэр өөрчлөх, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлах, түүнд өөрчлөлт оруулах үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 64 дүгээр тогтоолын хэрэгжилтийг 2024 онд батлагдсан бүх архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургийг хангуулан хянаж баталгаажуулав.

Нийслэлийн Орон сууцны бодлогын газраас зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж, 2024 оны 03/301 дугаар Зөвлөмж хүргүүлэх албан бичиг ирүүлсний дагуу 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр №НХААГ202311392/01 дугаар бүхий “Сэлбэ дэд төв” орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл, олон улсын зөвлөх үйлчилгээ, зураг төсөл боловсруулах гэрээг “ББСМО” ХХК-тай байгуулсан. Гүйцэтгэгч компанид батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зурган болон тоон мэдээллийг 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 02/1111 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Толгойт дэд төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл зөвшилцсэн. Гадна инженерийн шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажлыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэхээр төлөвлөж байна. Төлөвлөж буй бохир усны шугам сүлжээний ажлын зураг төсөлд өөрчлөлт оруулахаар санал ирүүлсэн. Толгойт дэд төвийн хүрээнд одоо байгаа 110/10 кВ-ийн толгойт дэд станцыг өргөтгөх ажил хийгдэхээр тендер зарлах бэлтгэл ажил хангагдсан.

Тохижилт, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг дэмжих ажлын хүрээнд тохижилтын 28 ажлын даалгавар 24 загвар зураг батлагдсан бөгөөд тус бичиг баримтыг иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэн өгөв.

Хотын хөгжлийн индексийн холбогдох шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангуулж ажиллана.

Хотын хөгжлийн индексийг шинэчлэн тооцох, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны урьдчилсан төлөвлөгөөнд тусгах 33 индексийн саналыг “Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төв” НТҮГ-т 2024 оны 01-01/169 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

Хотын хөгжлийн индексийн өөрийн байгууллагын хамаарах үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд 33 индексийг хэрэгжүүлэн ажиллахаар саналаа хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг заасан хугацаанд тайлагнан ажиллана.

Хотын хөгжлийн индексийн холбогдох шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангуулж ажиллах ажлын хүрээнд Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэлтэй батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл, авто зам, хил хязгаар, төмөр замын тоон мэдээллийг дундын мэдээллийн санг боловсруулж буй ubengineering компанид хүргүүлэв.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана.

Албан хаагчдад цахим (eDoc) хэлбэрээр албан бичиг боловсруулахад гаргадаг алдаа, зөрчлийг гаргахгүй байх талаар арга зүйн зөвлөгөөг тухай бүрд нь өгч, ирсэн албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, зөрчлийг бууруулан ажиллав.

- Нийт явсан бичгийн тоо - 1215
- Шийдвэрлэлтийн дундаж хугацаа - 5 хоног
- Шийдвэрлэлтийн хувь - 99.8%

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана.

Иргэдээс ирүүлсэн нийт 919 өргөдөл, гомдлыг бүртгэлд авч, шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллав.

- Хугацаандаа шийдвэрлэсэн - 846 буюу 89.0%
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн - 2 буюу 0.00%
- Судлагдаж байгаа - 72 буюу 10.0%
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног,
- Нийт 29 зөрчил бүртгэгдсэн.

Мөн 7 хоногийн шийдвэрлэлтийн мэдээг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд тухай бүр хүргүүлэн ажиллав.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах, шийдвэрлэлтэд хяналт тавих чиглэлээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын санал солилцох хамтарсан уулзалтад 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр оролцсон. Тухайн уулзалтын шийдвэрийн дагуу Өргөдөл гомдол шийдвэрлэлт, өргөдлийг хүлээн авч шилжүүлэхэд анхаарах асуудал болон байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний мэдээллийг боловсруулан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн албан хаагчид болон Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад 2024 оны 01 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд цахимаар танилцуулав.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль, зүйн үндэслэлтэй нэг мэр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг ханган ажиллана.

Нийт албан хаагчдын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх зорилготойгоор Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар Хот байгуулалт, хөгжлийн газрын Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлтэд (12.2.6.албан бичиг (хариутай болон хариугүй), өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн, шийдвэрлэлтийн явцад 2 удаагийн зөрчил гаргасан албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно) заалтыг оруулж, үүрэг хариуцлагыг дээшлүүлэн ажиллав.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд өдөр тутмын хяналт тавьж, судлагдаж байгаа өргөдөл, гомдолд 10 хоног тутам явцын тэмдэглэл хөтөлж, зөрчил гаргахгүй байхыг нийт албан хаагчдад "Spark" дотоод сүлжээгээр мэдэгдэж ажиллав.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд 2024 оны 01-01/799 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцад гарсан зөрчлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 буюу 15 хувиар буурсан байна.
- Өргөдөл, гомдлын хандалт 4 буюу 0,4 хувиар өссөн,
- Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1 хоногоор өссөн үзүүлэлттэй байна.

Нийслэлийн Засаг даргын "Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 2024 оны А/91 дүгээр захирамжийн дагуу тус газарт 2021-2023 онд ирүүлсэн гомдол шийдвэрлэлтийн байдалд хөндлөнгийн үнэлгээ

хийлгэх 10/04-202302 дугаар гэрээг Судлаач, Тэргүүлэх аудитор Б.Анхzáяатай байгуулан 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгүүлэв. Дээрх ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг холбогдох албан хаагчдад танилцуулан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 01-01/419 дугаартай албан бичгээр хүргүүлэв.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгнө.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 онд үүссэн нийт 1486 архивын баримтыг хуваарийн дагуу 2024 оны 1 дүгээр улиралд бүрэн хүлээн авав. Үүнээс:

- Байнга хадгалах 558,
- Түр хадгалах 129,
- 70 жил хадгалах 4,
- Байгууллага дээр байнга хадгалах баримт хувийн хэрэг 786,
- Зураг төслийн баримт 2,
- Цахим CD-7ш баримтыг данс бүртгэл үйлдэн хүлээн авсан.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд зарим агентлагийг өөрчлөн зохион байгуулах тухай" А/430, А/443 дугаар захирамжаар байгууллагын бүтэц орон тоонд өөрчлөлт орсонд холбогдуулан Нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар татан буугдаж чиг үүрэг манай газарт ирсэнтэй холбогдуулан тус газраас баримт актаар шилжүүлэн авсан. Үүнд:

- Байнга хадгалах хадгаламжийн нэгж 89,
- Түр хадгалах хадгаламжийн нэгж 169,
- 70 жил хадгалах хадгаламжийн нэгж 18,
- Тусгай төрлийн хадгаламжийн нэгж 2,
- Зургийн цомог 1 нийт 279 баримт актаар хүлээн авсан.

Хотын стандарт, хяналтын газрын стандарт хэрэгжүүлэх чиг үүрэг манай газарт шилжсэнтэй холбогдуулан нийт 123 хадгаламжийн нэгж хүлээн авав. Үүнд:

- Байнга хадгалах хадгаламжийн нэгж 43,
- Түр хадгалах хадгаламжийн нэгж 79,
- Тусгай төрөл 1 актаар хүлээн авч данс бүртгэл үүсгэв.

Хот байгуулалт, хөгжлийн газрын Хот дахин хөгжүүлэх хэлтсийн чиг үүрэг Орон сууцны бодлогын газарт шилжсэнтэй холбогдуулан тус газарт 144 баримтыг акт үйлдэн хүлээлгэн өгөв. Үүнд:

- Байнга хадгалах хадгаламжийн нэгж 115,
- Түр хадгалах хадгаламжийн нэгж 29.

ЗОРИЛГО 3. ДҮРМЭЭР ХҮЛЭЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

Газраас үзүүлж буй үйлчилгээг иргэдээд шуурхай хүргэж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

Газраас үзүүлж буй 8 төрлийн 36 нэр төрлийн үйлчилгээ авах хүсэлтийг үйлчилгээний ажилтан болон цахим хэлбэрээр 4398 иргэн, хуулийн этгээдээс хүлээн авсан. Үүнд:

- Угтах үйлчилгээний цэгээр – 3422 буюу 78%
- Цахим хэлбэрээр - 976 буюу 22% хүсэлт

Нийт 4398 хүн, хуулийн этгээдээс барилга, хот байгуулалтын чиглэлийн үйлчилгээ авахаар хүсэлт ирүүлснээс

- Бүрэн шийдвэрлэсэн 3422
- Шийдвэрлэгдэх шатанд судлагдаж байгаа – 976 хүсэлт

Газраас үзүүлж буй үйлчилгээний тоон мэдээг тус бүрээр гарган 7 хоног бүрийн Пүрэв гарагт Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Төрийн үйлчилгээний шийдвэрлэлтийн хяналт хариуцсан ажилтан Б.Удвалын udval.b@ulaanbaatar.mn хаягт хүргүүлэн ажиллав. Үүнд:

- Зөвшөөрсөн хүсэлтийн тоо - 2254,
- Судалж буй хүсэлтийн тоо - 976,
- Татгалзсан хүсэлтийн тоо – 1169

Нийт хүсэлтийг үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл:

- Архитектур төлөвлөлтийн даалгавар авах хүсэлт 1227 буюу нийт ирүүлсэн хүсэлтийн 28%
- Барилгын загвар зураг батлуулах хүсэлт 525 буюу нийт ирүүлсэн хүсэлтийн 12%
- Барилгад хаяг дугаар авах, зурган мэдээллийн үйлчилгээ авах хүсэлт 1233 буюу нийт ирүүлсэн хүсэлтийн 28%
- Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, зориулалт өөрчлөх хүсэлт 658 буюу нийт ирүүлсэн хүсэлтийн 15%
- Инженерийн шугам сүлжээний зураг зөвшилцөх хүсэлт 715 хүн буюу нийт ирүүлсэн хүсэлтийн 16%
- Архивын лавлагага авах тухай хүсэлт 40 буюу нийт ирүүлсэн хүсэлтийн 1% тус тус эзэлж байна.

Хот байгуулалтын үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган захиргааны сөрөг акт гарсан тохиолдолд бүртгэлжүүлж мэдээлж ажиллана.

Захиргааны сөрөг акт гарах тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу эрх ашиг нь хөндөгдөж буй давхардсан тоогоор 24 иргэн, хуулийн этгээдэд захиргааны сонсох ажиллагаа явуулсан. Үүнд:

- Архитектур төлөвлөлтийн даалгавар 5, Загвар зураг 1, Барилгын ажлын зөвшөөрлийн 4 гэрчилгээ хүчингүй болгож,
- Архитектур төлөвлөлтийн даалгавар 5, Загвар зураг 6, Барилгын ажлын зөвшөөрлийн 1 гэрчилгээг түдгэлзүүлж ажилласан.

Мөн 17 Архитектур төлөвлөлтийн даалгавар, 15 Загвар зурагт кодификаци хийв.

eBarilga.ub.gov.mn хот байгуулалтын цахим системд мэдээллийг оруулах, баяжилтыг тогтмол хийж ажиллах

eBarilga.ub.gov.mn геопорталын баригдсан барилга давхаргад хаяг дугаар шинээр авсан 832 барилгын 30 төрлийн мэдээллийг, тэг тэнхлэг давхаргад 108ш барилга байгууламж, 58ш инженерийн шугам сүлжээний мэдээллийг хүлээн авч барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн талбарт нийт 10-15 төрлийн мэдээллийг бүртгэж, баяжилтыг тогтмол хийсэн.

eBarilga.ub.gov.mn мэдээллийн санд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд маргаан үүссэн байршил унадад эрх зүйн тодруулга, эрх зүйн нэмэлт тайлбар хэсгийн мэдээллийг хөтөлж, тухай бүр шинэчлэв.

Мөн Нийслэлийн Засаг даргын захирамжаар болон газрын даргын тушаалаар хүчингүй болсон түдгэлзсэн актын талаарх мэдээллийг тухай бүр дотоод сүлжээ, *eBarilga.ub.gov.mn* мэдээллийн санд байршиулав.

Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбоодох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршиулна.

Гамшигт тэсвэртэй, эрчим хүчний хэмнэлттэй Өрөгт бүтээц болон Төмөр бетон бүтээцтэй 40м2, 60м2, 80м2, 100м2, 120м2 талбайтай, суурийн 3 төрлийн шийдэл бүхий нэг маягийн амины орон сууцны ажлын зургийг Хот байгуулалт, хөгжлийн газрын захиалгаар зураг төслийн Эм эм инженеринг ХХК боловсруулж Барилгын хөгжлийн төвөөс иж бүрэн ажлын зураг төсөвт магадлал хийж, эрчим хүчний В ангиллын гэрчилгээ олгосон. Эдгээр 10 төрлийн нэг маягийн ажлын зураг төсвийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хот байгуулалт, хөгжлийн газар, Онцгой байдлын ерөнхий газрын цахим хаягаар иргэдэд үнэ төлбөргүй ашиглаулж байна.

БУСАД ТОМООХОН АЖЛЫН ХҮРЭЭНД:

Нийслэлийн Онцгой Комиссын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн үүрэг даалгаврын дагуу Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах галд өртсөн орон сууцны 207 дугаар байранд биет судалгаа, хэмжилт хийж гүйцэтгэв.

Тус хэмжилтээр барилгын төлөв байдал болон бетон бүтээцийн бат бэхийг үл эвдэх сорилын Diginchmidt багажны тусламжтай тодорхойлж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Нийслэлийн Онцгой комисст хүргүүлсэн.



Барилга, хот байгуулалтын Сайдын 2024 оны 18 дугаар тушаалаар Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Гал түймэр, дэлбэрэлтэд өртсөн 207, 830 дугаартай барилга байгууламжийн хийц бүтээцийн бат бэхийн чанар, төлөв байдлыг тогоох, лабораторийн туршилт, шинжилгээ хийж, үнэлгээ өгч, нэгдсэн дүгнэлт гаргах, урьдчилсан төсвийг тооцох зэрэг ажлыг хийж гүйцэтгэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажилласан

2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан Бүсчилсэн хөгжлийн форумд Нийслэл Улаанбаатар хотын зүгээс тусгуулах хот байгуулалт, дэд бүтэц, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, дагуул хотуудын хөгжлийн асуудлыг танилцуулж шийдэл боловсруулж оролцсон.



Газрын даргын 2024 оны А/17 дугаар тушаалаар байгуулагдсан Спорт хамтлаг Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын нийт албан хаагчдын дунд 5 төрөлт спорт наадмыг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд бэлтгэл ажлыг хангуйж, амжилттай зохион байгуулж ажилласан.



Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/241 дүгээр захирамжийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан “Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтэд тус байгууллагаас 5 км гүйлтийн төрөлд 8 тамирчин, 10 км гүйлтийн төрөлд 3 тамирчин амжилттай оролцсон.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/64 дүгээр захирамжаар байгуулагдсан “Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны Ар гүнтийн ам, 24 дүгээр хорооны Баруун салаа, 34 дүгээр хорооны Баянголын ам, 42 дугаар хорооны Зүүн салаа, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны Хонхор, 20 дугаар хорооны Энгэр шанд, Арцат Хуандай аманд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх ажиллагааг холбогдох журамд нийцүүлэн зохион байгуулж, захиалагчийн хяналт тавих, зохих журмын дагуу хүлээлцэх үүрэг бүхий ажлын хэсэг”-т ажиллаж тус 2 дүүрэгт зуслангийн бүсэд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаварт санал өгч, хяналт тавьж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2024 ОНЫ А/226 дугаар захирамжийн дагуу нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргаж, хашаанд түр саатуулах ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэрийн суурьшлын бүсэд орж ирсэн 80 гаруй толгой малыг илрүүлэн, эздийг нь тогтоон хүлээлгэж өгсөн.



“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч “Барилгын салбарын бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт уулзалтыг нийслэлд үйл ажиллагаа явуулж буй барилгын салбарын бизнес эрхлэгч, инженерийн байгууллагын төлөөлөл, иргэн, хуулийн этгээдийн удирдлагуудтай 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 09:00-12.00 цагийн хооронд Монголын Хүүхдийн ордонд зохион байгуулав. Уулзалтад оролцох 782 иргэн, хуулийн этгээдэд цахим урилга хүргүүлсэн бөгөөд 310 иргэн, хуулийн этгээдэд биечлэн оролцов.

**“БАРИЛГЫН САЛБАРЫН
БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД
ТУЛГАМДАЖ БУЙ
АСУУДАЛ,
ШИЙДВЭРЛЭХ
АРГА ЗАМ” СЭДЭВТ
УУЛЗАЛТ**

ХОТЕЛБАР
09:00-09:30 Борчил
09:30-09:45 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар Улаанбаатар хотын барилгажилт, нийслэлээс баримттай бодлого чиглэгт илтгэл
09:45-10:45 Асуулт, хариулт
10:45-11:00 Саналт, дүнгэлт

БАЙШИЛ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Монголын хүүхдийн ордон


ХОЛБОО БАРИХ
+976 9908039, 99056734 | info@uba.ub.gov.mn



Нийслэлийн Засаг даргын А/116 дугаар захирамжаар байгуулагдсан “Хүүхдийн тоглоомын талбайн стандартын хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг”-т хэлтсийн 3 албан хаагч ажиллан төвийн 6 дүүрэгт хийгдэж буй хүүхдийн тоглоомын талбайн тохиижилтийн ажилд UCS1401B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандартын хэрэгжилтийг ханган ажиллах талаар арга зүйн зөвлөмж хүргүүлэн ажилласан.



Нийслэлийн Засаг даргын А/367 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн нутаг дэвсгэрт зөрчилтэй баригдсан хашаа хайс, орц гарцыг чөлөөлөх тухай захирамж, Хот байгуулалт, хотын стандартын газрын даргын Улаанбаатар хотын хорооллын дундах орц, гарцтай холбоотой зөрчлийг арилгаж, орц, гарц, гаргах ажлыг газар дээр нь судалгаа хийж шийдвэрлэх удирдамжын дагуу төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт хашаа хайс болон самбар буулгах ажилд оролцон мэдээг гаргаж танилцуулгыг бэлдэж ажиллав.



ТАНИЛЦСАН: ГАЗРЫН ДАРГА

Г.БАТЗОРИГ

ХЯНАСАН: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ДАШЦЭЦЭГ

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Л.ЭНХТУУЛ

ТАЙЛАН БИЧСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Л.АДЬЯАСҮРЭН